



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/585

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай" 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам", Монгол Улсын Засгийн газрын 2014 оны "Журам, чиглэл шинэчлэн батлах тухай" 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам батлах тухай" А/316 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/219 дүгээр тушаалын Мэндсайхан овогтой Бөртчинд холбогдох хэсгийг Ганболд овогтой Уянга Канад улс, University of British Columbia их сургууль, Нийгмийн шинжлэх ухаан мэргэжлээр 4 жил, Ганзориг овогтой Хуланд холбогдох хэсгийг Батбаатар овогтой Тулгаа, АНУ-улс, San Jose State University их сургууль, Программ хангамжийн инженер мэргэжлээр 4 жил, Ганболд-Баттулга овогтой Уянгад холбогдох хэсгийг Энхболд овогтой Биндэръяа, Австрали улс, University of Roehampton их сургууль, Хүний нөөцийн удирдлага мэргэжлээр 4 жил, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/217 дугаар тушаалын Энхзол овогтой Санчирт холбогдох хэсгийг Загдраднаа овогтой Оюунтөгс, Англи улс, University of Glasgow их сургууль, Хот төлөвлөлтийн инженер мэргэжлээр 4 жил, Жигмэдсанжаа овогтой Анандад холбогдох хэсгийг Болдбаяр овогтой Мэргэн Англи улс, University of Westminster их сургууль, Бизнесийн менежмент мэргэжлээр 4 жил, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны А/300 дугаар тушаалын Лутбаяр овогтой Өнө-Эрдэнэд холбогдох хэсгийн Манчестерийн их сургууль гэснийг Ливерпүүлийн их сургууль гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /М.Ариунжаргал/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Т.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД  Ц.ЦОГЗОЛМАА

302177